

**“МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХАД МАЛЧИН
ЭМЭГТЭЙЧҮҮД, ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО”**

СЭДЭВТ

БЭЛЧЭЭРИЙН ҮНДЭСНИЙ VIII ФОРУМААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Нүүдлийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн үндэс болсон бэлчээрийн нөөц хүрэлцээ сүүлийн жилүүдэд доройтон, хэдэн мянган жилийн туршид эх газрын эрс тэс уур амьсгалд байгалийн шалгарлаар дасан зохицож, хөгжиж бий болсон нутгийн үүлдрийн мал сүрэг, ургамлын төрөл зүйл, зэрлэг амьтдын амьдрах орчин хумигдаж, төрөл зүйл нь цөөрч, байгалийн тэнцвэр алдагдах хандлага ажиглагдаж эхэллээ. Сүүлийн 10 гаруй жил хийсэн судалгааны үр дүнд тал хээр нутгийн 65 хувь буюу 72 орчим сая га газар талхлагдсан ч байгалийн жамаараа нөхөн сэргэх чадавх нь хадгалагдан үлдсэн байна. Зөвхөн ачааллыг нь бууруулж, аажмаар малын тоогоо бэлчээрийн даацад тохируулах бодлогыг шат дараатайгаар хэрэгжүүлбэл байгаль аяндаа өөрийгөө нөхөн сэргээх боломж байна.

Өвөрхангай аймгийн Тарагт сумын Өгөөмөр рашаан сувиллын Соёлын төвд 2025 оны 09-р сарын 23-24-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад малчин эмэгтэйчүүд болон залуучуудын оролцоо” сэдэвт Бэлчээрийн Үндэсний VII форумд Монгол улсын төрийн захиргааны төв байгууллага, олон улсын төсөл хөтөлбөр, орон нутгийн захиргаа, аймгууд малчид, малчдын хэсэг бүлгийн төлөөлөл, аймаг сумдын малчин өрхийн анхдагч холбоо, дотоод гадаадын төрийн бус байгууллагын төлөөлөл болох 130 гаруй хүн оролцож, дээрх сэдвүүдээр 20 гаруй илтгэл мэдээлэл хэлэлцэж, 10 гаруй ханын илтгэл, 6 бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулан дараах зөвлөмжийг гаргав.

Бэлчээрийн форумд оролцогсдоос Ази тивийн эмэгтэй малчдын бүсийн хуралд хоёр эмэгтэй малчин Монгол улсаа төлөөлөн оролцохоор сонгогдлоо. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар, ХАА болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад:

1. Малчдын бэлчээр нутгаа ашиглах, сэргээн сайжруулах, хамгаалах эрх болон үүргийн хамтатгасан бодлого, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар уур амьсгалын болон бэлчээр нутгийн ашиглалтад явагдаж буй өөрчлөлтөд дасан зохицоход таатай боломж бүрдүүлэх, Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй, хүнсний аюулгүй байдлыг хангаж чадах хэмжээнд бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах,
2. Байгалийн аливаа экосистемийн хэвийн үйл ажиллагаа, бидний амьдрах орчныг тэтгэх үйлчилгээний цогц, тасралтгүй үргэлжлэх тогтвортой байдал бэлчээрийн чанарыг алдагдуулах, бэлчээрийг доройтуулалгүйгээр ашиглахын тулд Малчин өрхийн анхдагч холбоотой гэрээлэн ашиглуулах эрхзүйн зохицуулалтыг сайжруулах нөхцөлийг яаралтай бүрдүүлэх,
3. Мал ахуйн эрчимтэй хөгжилд малчин эмэгтэйчүүд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэхийн тулд ХАА-н салбарын жендерийн үнэлгээнд суурилсан Хөдөө аж ахуйн салбарын жендерийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх,
4. Залуу малчдын залгамж халааг бүрдүүлэх, хөдөөд залуучуудын ажиллах амьдрах таатай орчин, нөхцөл бүрдүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх,
5. Хөдөөгийн малчдын нийгмийн эрүүл мэндийн суурь судалгааг эрүүл мэндийг хамгаалах төрийн захиргааны дэмжлэгтэй зохион байгуулж урт дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,
6. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахын тулд бүс нутгийн онцлогт тохирсон шилмэл үүлдрийн малын үүлдэр угсааг сайжруулах, үржлийн цөм сүргийн мал бойжуулахад Малын үржлийн ажлыг гардан хэрэгжүүлэх малын үржүүлэг-технологийн нэгжид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
7. Бүх төрлийн малыг ээмэгжүүлэх, чип, кодоор хангах замаар мал сүргийн бүртгэлийн нэгдсэн системд суурилсан малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог бүрдүүлэн хүнсний эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулах бодлого гарган хэрэгжүүлэх,
8. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.2.2-т “Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн

- төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр шинэчлэн тогтоож малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана” гэснийг хэрэгжүүлэх,
9. Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээр, Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор баталсан уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтууд түүний дотор 2030 он гэхэд Хөдөө аж ахуй салбарт 5,28 сая тонн дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг яаралтай боловсруулан хэрэгжүүлэх,
 10. Монгол Улсын хэмжээнд байгалийн бүс бүслүүрээр хөрс, ургамлын бүрхэвчийн нүүрстөрөгчийн шингээгүүрийн суурь үзүүлэлтийг тогтоох, хөдөө аж ахуйн салбарын нүүрстөрөгчийн шингээлт, ялгаруулалтад аудит хийх үндэсний чадамжийг бүрдүүлэхэд ХАА-н асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас дэмжлэг үзүүлэн ажиллах,
 11. Малын тоо толгойн албан татварыг орон нутагт ялгаатай тогтоодог, бүрдүүлсэн татварын зарцуулалтын ангилал хэт өргөн хүрээтэй байгаа нь Монгол Улсын Татварын Ерөнхий хуулиар тогтоосон үндсэн зарчмууд тодорхой байх, зайлшгүй байх, шударга байх зарчмуудыг алдагдуулж байгаа тул нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан УИХ-р хэлэлцүүлэх,
 12. 2026 онд болох Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жилийн хүрээнд Монголын бэлчээрийн мал аж ахуйн дахин давтагдашгүй шинжийг олон улсад сурталчлан таниулах, нүүдлийн мал аж ахуйд аюул учруулж байгаа тулгамдсан асуудлыг тодорхойлон засаж сайжруулах талаар нийгмийн олон талыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулж шийдвэрлэх арга замыг тодорхойлох,

Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга нарт:

1. Орон нутагт залуу малчдын ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд онцгой анхаарч залуучууд, эмэгтэйчүүдийн манлайллыг хөхиүлэн дэмжих бодлого, бодит хөшүүрэг механизмыг буй болгон хөгжүүлэхэд анхааран ажиллах,
2. Орон нутагт малчдын хүрэлцээ, жендерийн асуудлаар ард нийтийн зөвлөлдөх хэлэлцүүлэг зохион байгуулан тулгамдсан асуудлуудыг тодорхойлон сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, сумын урт дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг болох,
3. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, малын тэжээлийн нөөцийг сайжруулах, малын үүлдэр угсааг сайжруулахад чиглэсэн шимт өвсний шахмал, ногоон дарш бэлтгэх, хадлангийн талбай сайжруулах, хээлтэй малыг угтуулан болон дагуулан тэжээх, малын өтөг бууцыг боловсруулан ашиглах, малын зохиомол хээлтүүлэг, хөврөл шилжүүлэн суулгах шинэлэг арга технологийг орон нутгийн малчин өрхийн холбоод, хоршоодод дэлгэрүүлэхийг орон нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагаас дэмжин ажиллах,
4. Малчид болон бусад хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид олгох ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хувийн секторын ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаанд оруулж хувь нэмрийг тооцох, тайлагнах, баталгаажуулах тогтолцоог хөгжүүлэхэд анхаарах,
5. Орон нутгийн банк санхүүгийн байгууллагуудтай хамтран малчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, аялал жуулчлал, гар урлал, бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээгдэхүүний маркетинг зэрэг чадамжид суурилсан боловсролыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах хэрэгжүүлэх,
6. Малчдын залуу халааг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахыг дэмжсэн урамшуулал, идэвхжүүлэх, оролцоог сайжруулах нутгийн онцлогт тохирсон журам, зохицуулалтыг буй болгон хэрэгжүүлэх, Зудад нэрвэгдсэн залуу малчдыг малжуулах, санхүүгийн болон биет туслалцааг эхний ээлжид үзүүлэхэд анхаарч ажиллах,

Малчин Өрхийн Анхдагч Холбоод болон малчны өөрөө удирдах байгууллагын оролцогч талуудад:

1. “Хариуцлагатай Нүүдэлчин” бэлчээрийн мал аж ахуйн зохистой дадлын стандартыг хэрэгжүүлэн дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, гарал үүсэл тодорхой, малын гаралтай түүхий эдээ урамшуулалт үнээр борлуулж гишүүн малчдын бүлэг, хоршоодын жишээг бусад малчдад сурталчлах, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн стандартыг нэвтрүүлэхэд орон нутгийн захиргааны байгууллагаас хяналт, болон туслалцаа үзүүлдэг байх,

2. Эдэлбэр газрын жам ёсны эрхээ баталгаажуулах үүднээс Малчин Өрхийн Анхдагч холбоод гишүүн малчдын бэлчээрээ урт хугацаагаар гэрээлэн ашиглах ажлыг хууль дүрмийн хүрээнд шуурхай зохион байгуулан манлайлалтай байх,
3. Малчин өрхийн холбоод хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гишүүдийн эрх ашгийг хамгаалах, залуу, эмэгтэй малчдын бизнесийг хөгжүүлэх, гишүүдийнхээ малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд зуучлан борлуулах, цас борооны ус цуглуулах, хөв цөөрөм байгуулах, хадлангийн талбайд цас тогтоох, дошин халиах, хадлан тэжээл бэлтгэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах санаачилгыг орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
4. Орон нутгийн малчны өөрөө удирдах байгууллагууд бэлчээр, хөрсний нүүрсхүчлийн хийн одоогийн шингээгүүрийг тогтвортой хадгалан нүүрстөрөгчийн зах зээлээс урамшуулал авах механизмыг идэвхтэй ашиглахын төлөө ажиллах, төсөл хөтөлбөр санаачлах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах,

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Парисын хэлэлцээр түүнийг хэрэгжүүлэхэд Монгол улсын оруулах хувь нэмрийг зорилтот хугацаанд хэрэгжүүлэх, НҮБ-ийн Ерөнхий Ассамблейгаас 2026 оныг олон улсын бэлчээр ба нүүдлийн МАА эрхлэгчдийн жил болгон зарласантай холбогдуулан зохион байгуулагдах аливаа үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нүүдэлчдийн өв соёл, бэлчээрийн мал маллагааны байгальд ээлтэй үнэт уламжлалаа хадгалан ирээдүй үедээ өвлүүлэх их үйлсэд идэвхтэй, манлайлан оролцохыг Бэлчээрийн Үндэсний VIII форумд оролцогчид бид санал нэгтэй дэмжин уриалж байна.

ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГСОД,

2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр

Өвөрхангай аймаг Тарагт сум, Өгөөмөр